



**САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2025 он

ЗАРДЛЫН ТООЦОО

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дахь заалтад нийцүүлэн Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал” /цаашид “Аргачлал” гэх/-ын дагуу дараах байдлаар тооцлоо.

Уг аргачлалын 1.2-т заасны дагуу зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог бөгөөд энэхүү хуулийг хэрэгжүүлэхэд иргэнд зардал үүсэхгүй болно.

НЭГ. Хуулийн этгээдийн хувьд гарах зардлыг дараах үе шаттайгаар зохион байгуулав. Үүнд:

1. Хуулийн этгээд гүйцэтгэх үүргийг тогтоох;
2. Зардлыг тооцох;
3. Тоон үзүүлэлтийг тооцох;
4. Нийт зардлын дүнг тооцож гаргах;
5. Хялбарчлах боломжийг шалгах;
6. Нэмэлт зардлыг тооцох.

Нэгдүгээр үе шатны хүрээнд: Хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдийн хүлээх үүргийг энд тодорхойллоо. Хуулийн төслийн дагуу хуулийн этгээд /санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч/ дараах үүргийг хүлээж байна.

8.1.Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь бусад хууль тогтоомжид зааснаас гадна дараах үүргийг хүлээнэ:

8.1.7.санхүүгийн хэрэглэгчийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн тухай нэгдсэн тайлан, мэдээг тогтоосон хугацаанд зохицуулагч байгууллагад хүргүүлэх;

15.3.Зохицуулагч байгууллага энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд дараах дүрэм, журам, заавар, аргачлалыг батална:

15.3.4.санхүүгийн хэрэглэгчийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн тайлан, мэдээний загвар;

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөлд тусгасны дагуу санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь зохицуулагч байгууллагаас баталсан загварын дагуу санхүүгийн хэрэглэгчийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн тухай нэгдсэн тайлан, мэдээг хүргүүлэх үүрэгтэй.

Хоёрдугаар үе шатны хүрээнд: Гүйцэтгэх үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүнд зарцуулах хугацааг тодорхойлсны үндсэн дээр нэг хуулийн этгээдэд үүсэх мөнгөн зардлыг тооцов.

Хуулийн этгээд	Хэрэгжүүлэх чиг үүрэг	Хийгдэх ажиллагаа	Зарцуулах хугацаа	Давтамж /хагас жилд нэг удаа гэж тооцвол/	Хүний нөөцийн хэрэгцээ
Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч	Санхүүгийн хэрэглэгчийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн тухай нэгдсэн тайлан, мэдээг хүргүүлэх	Тайлан, мэдээ нэгтгэх	55 мин		110 мин
		Тайлан мэдээг хүргүүлэх	5 мин	2	10 мин
Нийт					120 мин

Нэгдсэн тайлан, мэдээг хүргүүлэх ажилд нэг жилд 2 цаг зарцуулах бөгөөд 1 ажилтан нэг жилд 1600 цагаар ажиллана гэж тооцвол $2:1600=0.001$ хүний нөөцийн хэрэгцээ бий болно. Иймд тус үүргийг хэрэгжүүлэхэд нэмэлт хүний нөөцийн зардал гарахгүй гэж үзлээ.

Гуравдугаар үе шатны хүрээнд: Тоон үзүүлэлтийг тооцох зардлыг хуанлийн 1 жилийн хугацаанд тухайн үүргийг хуулийн этгээд хэдэн удаа хэрэгжүүлэхээс хамаарч гаргадаг бөгөөд дээрх хүснэгтийн дагуу жилд 2 удаа хэрэгжүүлэхээр байна.

Дөрөвдүгээр үе шатны хүрээнд: Нийт зардлын дүнг тооцох үе шатанд тухайн үүргийг гүйцэтгэхэд шаардагдах зардлыг тоон үзүүлэлтээр үржүүлж гаргадаг бөгөөд хоёрдугаар үе шатны хүрээнд тооцсон зардал өөрчлөгдөхгүй.

Тавдугаар үе шатны хүрээнд: Энэ шатанд хялбарчлах боломжийг шалгадаг бөгөөд өмнөх үе шатанд тодорхойлсон үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг дараах асуулгаар тодруулж гүйцэтгэлээ.

№	Асуулга	Тайлбар
1.	Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх	Монголбанк, Санхүүгийн зохицуулах олгосон зөвшөөрөл, бүртгэлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдүүд бүгд хэрэгжүүлэх үүрэгтэй.

2.	Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх;	Боломжтой. Зохицуулагч байгууллагаас баталсан тайлан, мэдээний загвараар зохицуулагдана.
3.	Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;	Боломжтой. Зохицуулагч байгууллагаас баталсан тайлан, мэдээний загвараар зохицуулагдана.
4.	Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх;	Байхгүй.
5.	Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;	Боломжтой. Зохицуулагч байгууллагаас баталсан тайлан, мэдээний загвараар зохицуулагдана.
6.	Нэг цэгийн үйлчилгээ бий болгох боломжтой эсэх гэх мэт.	Шаардлагагүй.

Зургаадугаар үе шатны хүрээнд: Энэ шатанд тухайн үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарч болох нэмэлт зардлыг тооцох бөгөөд Зохицуулагч байгууллагаас батлах тайлан, мэдээний загвараас хамааран бичиг, заасны зардал нэмэгдэх боломжтой байна.

ХОЁР. Төрийн байгууллагын хувьд гарах зардлыг дараах үе шаттайгаар зохион байгуулав. Үүнд:

1. Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
3. Гарах зардлыг урьдчилан тооцох;
4. Зардлыг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Зардлын тооцоог хийхдээ хууль тогтоомжийн зохицуулалтад хамааралтай төрийн байгууллага нэг бүрийг тодорхойлж, тэдгээрийн үйл ажиллагааны хоорондын уялдаа холбоог анхаарч үзэв.

Нэгдүгээр үе шатны хүрээнд: Хуулийн төслийн дагуу Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо /зохицуулагч байгууллага/ дараах үүргийг хүлээж байна.

15.1.Зохицуулагч байгууллага нь хуульд заасан чиг үүргээс гадна санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хүрээнд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

15.8.Зохицуулагч байгууллага санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий бие даасан нэгж, орон тоотой байна.

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөлд тусгасны дагуу зохицуулагч байгууллага нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий бие даасан нэгж, орон тоотой байхаар байна.

Хоёрдугаар үе шатны хүрээнд: Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон тохиолдлын тоог, нэг ажилтанд шаардагдах нийт ажлын цагийн хамт тооцож гаргана. Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд заасан санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих чиг үүрэг нь үргэлжилсэн шинжтэй, тасралтгүй хийгдэх ажил тул тогтоох боломжгүй тохиолдлын тоонд хамаарч байна. Иймд, шаардагдах хүний нөөцийг баримжаалан тооцов.

Жилээр/сая төгрөг

1	Төрийн байгууллага	Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо
2	Хүний нөөцийн хэрэгцээ /Ажилтны тоо, баримжаагаар/	10 ажилтан
3	Цалингийн зардал	520.0
4	Материаллаг зардал техник, тоног төхөөрөмж	40.0
5	Урсгал зардал	30.0
Нийт		590.0

Зохицуулагч байгууллага нь санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий бие даасан нэгж, орон тоо бий болгох, Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хуулийн хэрэгжилтийг хангах үүргийг хэрэгжүүлэхэд нэг жилд 590 сая төгрөгийг зардал гарна гэж үзлээ. Түүнчлэн бусад үе шатанд дээрх хүснэгтэд дурдсан тооцоолол өөрчлөгдөхөөргүй байна.

___о0о___